



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Шар усны үерийн аюулаас урьдчилан Г
сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хөрсний ус, айл өрхийн хашаа байшин гэр, гудамж талбай, авто зам дээр мөс тогтож хаврын дулааралтын үеэр хайлж урсан шар усны үер үүсэж болзошгүй байна.

Иймд нийслэлийн үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугам, авто замын доогуурх ус гадагшлуулах сувгийн ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангах, болзошгүй шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Нийслэлийн Онцгой комиссоос ДААЛГАХ нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай:

1.1 Дүүргүүдийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт:

а/ дүүргийн нутаг дэвсгэрт байрлах үерийн хамгаалалтын барилга байгууламж, ус урсах гуу жалга, авто зам доогуурх ус гадагшлуулах сувгийг цэвэрлэх, цаашид тухайн орчныг хог хаягдалгүй байлгах талаар арга хэмжээ авах;

б/ гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт хүч, хэрэгслийг дайчлан гаргах, дүүрэг, хорооны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хяналт тавих;

в/ болзошгүй шар усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар иргэд олон нийтэд мэдлэг дадлагыг олгох арга хэмжээг зохион байгуулах;

г/ ус, цаг агаарын гэнэтийн үзэгдлийн үед аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах нөөцийг бүрдүүлэх;

д/ гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол хүргэх;

е/ далан сувгийн ойролцоо амьдарч байгаа айл өрхүүд цаашид далан сувагт хог хаях явдлыг таслан зогсоох, Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

ё/ үер усны аюулд өртөж болзошгүй айл өрхийн судалгаанд тодотгол хийж, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг богино хугацаанд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах;

з/ дүүргийн нутаг дэвсгэрт хүндрэл үүсэж болзошгүй газруудын судалгааг гарган, гадаргуугийн ус зайлуулах жижиг шуудуу, шугамыг тухайн орчны иргэд оршин суугчид, албан байгууллагатай хамтран өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэх.

1.2 Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-д:

а/ нийслэлийн үерийн хамгаалалтын байгууламжид холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалтыг тогтмол явуулж, далан сувгийн засварлалт, хог хаягдлын байдал, бусад шалтгаанаас үерийн ус чөлөөтэй нэвтрэх боломжийг алдагдуулж байгаа зөрчил, дутагдлыг шуурхай таслан зогсоох арга хэмжээг холбогдох дүүрэг, аж ахуйн нэгж байгууллагаар хэрэгжүүлж, үерийн хамгаалалтын далан сувгийг шинээр төлөвлөх, эвдрэлийг засварлах;

б/ нийслэлийн нутаг дэвсгэрийг шар ус, хур борооны үерийн аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллах, мэргэжлийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

в/ нийслэлийн Онцгой комиссын "Үер ус, цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг үүрэг даалгавраар ханган утас, хаягийн бүртгэлд тодотгол хийж бэлэн байдлыг хангуулах;

г/ гэнэтийн гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хоол, шатахууны бэлэн байдал, бусад шаардагдах хөрөнгийн нөөцийг бүрдүүлэн шаардлагатай тохиолдолд захиран зарцуулах.

1.3 Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга /Ж.Чүлтэмсүрэн/-т:

а/ үер усны аюулын үед шуурхай ажиллах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авах, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;

б/ нийслэл, дүүргийн үер ус, далан сувгийн ус нэвтрүүлэх чадамжийг сайжруулах талаар ажил хариуцсан албан тушаалтан, байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хяналт тавих.

1.4 Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ

/Т.Цэрэнноров/-т:


а/ үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугамын ашиглалтын хэвийн найдвартай ажиллагааг хангаж цас, мөс, хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.

1.5 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т:

а/ нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлж, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангуулах талаар хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын ажлыг нийтэд мэдээлэх, иргэдийн амь нас, өмч хөрөнгийг шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлж сурталчилах ажлыг зохион байгуулах.

2 Нийслэлийн нутаг дэвсгэрийг шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлж, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Үер ус цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай ажлын хэсгийн дарга Т Гантөмөрт, энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэлийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг дүүргүүдийн Засаг дарга болон холбогдох байгууллагын дарга нарт, ирүүлсэн мэдээг нэгтгэн 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга бөгөөд Нийслэлийн Онцгой комиссын орлогч Ж.Чүлтэмсүрэнд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН